



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/37

Улаанбаатар хот

Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан
бүсэд нэвтрэх үнэмлэхийн хураамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9, 10 дахь заалт, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийн хураамжийг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх үнэмлэхийн хураамжийг 2021 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Нисэх буудлуудын удирдах газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/04 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аюулгүй байдал, хамгаалалтын алба /М.Гомбожав/-нд, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар /Б.Батхишиг/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын
2021 оны 02 дугаар сарын 19 -ний өдрийн
А/3.1 дугаар тушаалын хавсралт



Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд нэвтрэх
үнэмлэхийн хураамж

/Төгрөгөөр/

№	Нэвтрэх үнэмлэхийн төрөл	Нэг жилийн хугацаатай	Түр хугацаатай
А. Тээврийн хэрэгсэл:			
1	Авиа компаниуд болон гадны байгууллагын технологи үйлдвэрлэлийн тээврийн хэрэгсэл /хориотой, хамгаалагдсан бүс/	165 000	55 000
2	Ажил үүргийн зайлшгүй шаардлагаар Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа алба салбарын ажилтан, албан хаагчдын хувийн тээврийн хэрэгсэл /хамгаалагдсан бүс/	55 000	33 000
3	Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны үйлдвэрлэлийн тээврийн хэрэгсэл	11 000	
4	Тээврийн хэрэгсэл өөрчлөгдсөн тохиолдолд	11000	
5	А хэсгийн 1 дэх заалтаас бусад	32 000	22 000
Б. Хувь хүн:			
1	Иргэний нисэхийн байгууллагууд болон нисэхийн үйл ажиллагаанд оролцогч	5 500	
2	Б хэсгийн 1 дэх заалтаас бусад тээврийн хэрэгсэл	32 000	22 000

Тайлбар:

1. Нэвтрэх үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгохдоо үнэлгээг 3 дахин нэмэгдүүлнэ.
2. Нисэх буудлын хориотой болон хамгаалагдсан бүсэд Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа алба салбарын ажилтан алба хаагчдын хувийн тээврийн хэрэгсэлд нэвтрэх үнэмлэх олгохдоо харьяа газрын даргын тодорхойлолтыг үндэслэн олгоно.
3. Нисэх буудлын хориотой, хамгаалагдсан бүсэд нэвтрэх хувийн тээврийн хэрэгсэлд олгох нэвтрэх үнэмлэхийг Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа алба салбарын үйлдвэрлэлийн хэсгийн дарга нар, нярвууд болон бичиг хэргийн 1 ажилтанд харьяа газрын даргын тодорхойлолтыг үндэслэн үнэгүй олгоно.